



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2018 оны 11 сарын 29 өдөр

Дугаар 11737

Арвайхээр

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1-ийн “г”, Статистикийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 2 дэх заалт, Засгийн газрын 2003 оны 224 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Өвөрхангай аймгийн нутаг дэвсгэрт байгаа мал, тэжээвэр амьтан, хашаа, худаг, тэжээлийн тооллогыг 2018 оны 12 дугаар сарын 7-ноос 17-ны өдрүүдэд явуулсугай.

2. Мал, тэжээвэр амьтан, хашаа, худаг, тэжээлийн 2018 оны тооллогыг аймгийн хэмжээнд удирдан зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: И.Доржсүрэн -аймгийн Засаг даргын орлогч

Гишүүд: О.Түмэнжаргал -аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн
дарга

С.Цэдэнбалжир -аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө аж ахуйн газрын
дарга

Б.Цэнгэл -аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө аж ахуйн газрын
Мал аж ахуйн албаны дарга

А.Нямдаваа -аймгийн Мал эмнэлэгийн албаны дарга

С.Зоригтбаатар -аймгийн Засаг даргын дэргэдэх Газрын харилцаа, барилга,

хот байгуулалтын газрын мэргэжилтэн Нарийн бичгийн дарга

Х.Мөнхцэцэг -аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн
Мэргэжилтэн

3. Мал, тэжээвэр амьтан, хашаа, худаг, тэжээлийн тооллогын бэлтгэл ажлыг хангах, тооллого явуулах ажлын хэсгийг сумдад байгуулж, ажилтнуудыг сургах, хяналтын тооллого хийх, тооллогын дүнг нэгтгэх үйл ажиллагааны зардалд 2000000 (хоёр сая) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Ц.Ганболд)-д зөвшөөрсүгэй.

4. Мал, тэжээвэр амьтан, хашаа, худаг, тэжээлийн тооллого явуулахтай холбогдон гарах шууд зардлыг төсвөөсөө санхүүжүүлэхийг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

5. Тооллогын бэлтгэл, зохион байгуулалтын ажлыг аймаг, сумын түвшинд хангаж, тооллогыг тогтоосон хугацаанд нь заавар, журмын дагуу чанартай явуулж, дүнг мэдээлэхийг Ажлын хэсгийн ахлагч (И.Доржсүрэн)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Г.ГАНБОЛД

011101554

D:My Doc. Zahiramj. Zasag darga